МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 09 өдөр Дугаар А/163. Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2. "Эрүүл шүд-эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Р.Оюунханд), Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа), Эмнэлгийн тусламжийн газар (М.Баттүвшин), үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөрт тусган ажиллахыг Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газар (Э.Содномжамц)-т тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг байгууллага, орон нутгийн түвшинд зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг орон нутгийн болон байгууллагын төсөвт тусгаж ажиллахыг бүх шатны Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Я.Амаржаргал)-т даалгасугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

080640

Эрүүл Мэндийн сайдын 2019 оны
04 дугаар сарын 09-ны өдрийн А/163 дугаар
тушаалын хавсралт

# "ЭРҮҮЛ ШҮД-ЭРҮҮЛ ХҮҮХЭД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Зорилго | Хүүхдийн шүдний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын дэвшилтэт арга туршлагыг нэвтрүүлэх замаар хүүхдийн шүдний өвчний тархалтыг 30%-иар, цоорлын эрчмийг 4 нэгжээр бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино. |
|---|---|
| Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт) | |
| 1. Үйл ажиллагааны чиглэл | Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл |

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах ажлын хэсэг | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, чадавхийг дээшлүүлэх, зүй зохистой байршуулах чиглэлээр салбарын бодлого, хөтөлбөрт тусгах замаар бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;** | | | | | | | |
| *1.1.* **Үйл ажиллагааны чиглэл 1.1** ***Шүдний өвчний оношилгоо, эмчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлээр:*** | | | | | | | |
| 1.1.1 Шүдний тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад салбарын оролцоог сайжруулах, өргөжүүлэх | | Шүдний чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж буй хувийн хэвшлийн шүдний эмнэлгийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж хамтран ажиллах; | Сонгон шалгаруулсан хувийн хэвшлийн байгууллагын тоо<br>Гэрээ байгуулсан хувийн хэвшлийн шүдний эмнэлгийн тоо | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ,<br>ЭТГ | ЭМДЕГ<br>Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2022 |
| | | "Эрүүл шүд–эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах | Хэрэгжилтийн тайлан<br>Оролцсон хүүхдийн тоо<br>Бусад | | ЭМЯ, ЭТГ<br>Аймаг, нийслэлийн ЗДТГ<br>Аймаг, | Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | салбарын оролцоо | | нийслэлийн ЭМГ | Холбогдох ТББ-ууд | |
| 1.1.2 Шүдний тусламж, үйлчилгээний бодит өртгийг тооцож, 16 хүртэлх насны хүүхэд залуусын шүдний эмчилгээг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх; | Шүдний тусламж, үйлчилгээний бодит өртгийг тооцох | Шүдний тусламж, үйлчилгээний өртгийн тооцоо | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ, БТГ, ЭЗСХОГ ЭМДЕГ Хөтөлбөрийн санхүүжилт, үр дүн, гүйцэтгэлийг хянах дэд ажлын хэсэг | Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019 |
| | Шүдний тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх талаар санал дэвшүүлэх, шийдвэрлүүлэх | Боловсруулсан санал Гарсан тушаал, шийдвэр | | | ЭМДЕГ, Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019 |
| ***1.2 Мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, чадавхийг дээшлүүлэх, зүй зохистой байршуулах чиглэлээр:*** | | | | | | |
| 1.2.1 Анхан шат, үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээнд тусламж үйлчилгээ үзүүлэх нүүр амны үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх | Нүүр ам судлалын үндсэн мэргэшлийн эмч (нүүр амны гажиг засал судлал, нүүр амны мэс засал судлал, нүүр амны согог засал судлал, хүүхдийн нүүр ам судлал, шүдний ерөнхий эмчилгээний эмч, шүдний эрүүл ахуйч) бэлтгэх | Аймаг, нэгдсэн эмнэлэг бүрт нэг | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ, ТЗУГ, ЭМХТ АШУҮИС Нүүр, ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл | АШУҮИС-ийн Нүүр, ам судлалын сургууль Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2022 |
| | Сувилагч (нүүр амны сувилахуй) бэлтгэх | Аймаг, сум бүрт нэг | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ, ТЗУГ, ЭМХТ АШУҮИС | АШУҮИС-ийн Нүүр, ам судлалын сургууль Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нүүр амны чиглэлээр үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмч, сувилагч нарын сургалтын хөтөлбөр боловсруулах | Сургалтын хөтөлбөр | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ, ТЗУГ, ЭМХТ Нүүр, ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл | АШУҮИС-ийн Нүүр, ам судлалын сургууль Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2022 |
| 1.2.2 Хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, өрхийн эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрт амны хөндийн эрүүл ахуйн чиглэлээр багц цагийн сургалтыг оруулж батлуулах | Хүүхэд, өрхийн эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах | Шинэчилсэн сургалтын хөтөлбөр | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | БСШУСЯ АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургууль Нүүр, ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл | Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2020 |
| | Шинэчилсэн сургалтын хөтөлбөрөөр сургалт явуулах | Сургалтын тоо Сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | БСШУСЯ АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургууль Нүүр, ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл | Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2022 |
| 1.2.3 Нүүр, ам судлалын мэргэжилтнүүдийн байршил, зохион байгуулалтыг бодлогоор зохицуулах | Орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан шүдний эмч бэлтгэх, ажиллуулах, нийгмийн баталгаа, цалин урамшууллын дэмжлэг үзүүлэх, орон нутгаас боловсон хүчнийг бэлтгэх | Орон нутгаас гарсан санал Хөдөө орон нутагт ажилласан эмч, мэргэжил/тоо | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургууль | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2022 |
| ***Зорилт 2.*** **Хүүхэд, эцэг эх, гэр бүлийн гишүүд болон хамт олны оролцоотойгоор шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **зүйлээс сэргийлэх, амны хөндийн эрүүл мэндээ хяналт тавих эрүүл зан үйлийг төлөвшүүлэх;** | | | | | | |
| ***2.1 Зорилтот бүлгийн амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр:*** | | | | | | |
| 2.1.1 Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулахад нутгийн захиргааны байгууллага болон шийдвэр гаргагчдын оролцоог нэмэгдүүлж, идэвхжүүлэх; | Орон нутгийн Засаг дарга, шийдвэр гаргагч нарт зориулсан сургалт, уулзалт зохион байгуулах | Уулзалт, сургалтын тоо Хамрагдсан шийдвэр гаргагчдын тоо | Амны хөндийн эрүүл мэндийн эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, маркетингийн дэд ажлын хэсэг | ЭМЯ, НЭМГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ Аймаг нийслэлийн ЭМГ | Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2022 |
| 2.1.2 Сургууль, цэцэрлэгт түшиглэн хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулж, дадал бий болгох, шүд угаах нөхцлийг бүрдүүлэх; | Бага насны хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлагыг сайжруулах, дадал бий болгох сургалтын хөтөлбөр боловсруулах, батлуулах | Батлагдсан сургалтын хөтөлбөр | | ЭМЯ, НЭМГ, ЭМХТ, Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | ЭМЯ, ТЗУГ, БСШУСЯ ТББ-ууд | 2019-2020 |
| | Сургууль, цэцэрлэгийн багш нар болон сургуулийн эмч нарт зориулсан амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр мэдлэг, дадал олгох сургалт зохион байгуулах | Уулзалт, сургалтын тоо Хамрагдсан багш нарын тоо | Амны хөндийн эрүүл мэндийн эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, маркетингийн дэд ажлын хэсэг | ЭМЯ, НЭМГ, ЭТГ, ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЗДТГ Аймаг нийслэлийн ЭМГ | БСШУСЯ ТББ-ууд | 2019-2022 |
| | Жирэмсэн эмэгтэй, төрсөн эхчүүдэд зориулсан хүүхдийн шүдийг хэрхэн арчлах талаар гарын авлага боловсруулах, хэвлэх | Боловсруулсан гарын авлага | | ЭМЯ, НЭМГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ Аймаг нийслэлийн ЭМГ | БСШУСЯ ТББ-ууд АШУҮИС | 2019-2020 |
| | Хүүхдийн шүдний эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмол явуулах телевизийн эфирийн цагт тусгах | Сурталчилгаа явуулах тогтмол эфирийн цаг | Амны хөндийн | ЭМЯ, НЭМГ Аймаг, нийслэлийн ЗДТГ Аймаг | БСШУСЯ ТББ-ууд | 2019-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эрүүл мэндийн эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, маркетингийн дэд ажлын хэсэг | нийслэлийн ЭМГ | | |
| | Эцэг эх, асран хамгаалагчдын дунд хүүхдийн шүд арчилгаа, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт сурталчилгааг хороо, байраар зохион байгуулж, сайн дурын идэвхтэн бэлтгэх | Сургалт сурталчилгааны тоо,<br>сайн дурын идэвхтэний тоо | | ЭМЯ, НЭМГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ | Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | 2019-2020 |
| | Бизнесийн байгууллагуудад зориулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулах | Сургалт, сурталчилгааны тоо<br>Оролцсон бизнесийн байгууллагын тоо | | ЭМЯ, НЭМГ, Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг Аймаг, нийслэлийн ЗДТГ, Аймаг нийслэлийн ЭМГ | БСШУСЯ ТББ-ууд | 2019-2020 |
| 2.1.3 Чихэр агуулсан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлаж, шүдэнд ээлтэй хоол хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх дэмжлэгт орчинг бүрдүүлэх; | Чихэрлэг ундаанд татвар ногдуулах эдийн засгийн тооцоолол, эрүүл мэндийн үр нөлөөллийг судлан, үр дүнг шийдвэр гаргагч нарт сурталчлах | Судалгааны үр дүн, уулзалт ярилцлагын тоо | Амны хөндийн эрүүл мэндийн эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, маркетингийн дэд ажлын хэсэг | ЭМЯ, НЭМГ, БТГ,<br>НЭМГ | ХХААХҮЯ Шүдний мэргэжилтний холбоо, АШУҮИС-ийн НЭМС, АУС | 2019-2020 |
| | Чихрийн агууламж өндөртэй хүнсний бүтээгдэхүүнд онцгой татвар ногдуулах замаар үйлдвэрлэл, импортын бүтээгдэхүүнийг хязгаарлах чиглэлээр бодлого, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах | Боловсруулсан бодлогын санал Өөрчлөлт оруулсан хууль эрх зүй, бодлогын баримт бичгийн тоо | | ЭМЯ, НЭМГ ХХААХҮЯ Сангийн яам | Шүдний мэргэжилтний холбоо, АШУҮИС-ийн НЭМС, АУС | 2019-2022 |
| | Хүүхдийн амны хөндийд ээлтэй бактери, пробиотикоор | Хүүхдэд ээлтэй хүнсний | | ЭМЯ,ЭҮТГ ШУТС | Судалгаа шинжилгээний | 2019-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | баяжуулсан хүнсийг ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, нийтийн худалдаанд нэвтрүүлэх | бүтээгдэхүүний тоо | | БСШУСЯ Хувийн хэвшил | байгууллагууд | |
| 2.1.4 Сургууль, цэцэрлэгийн орчинд чихэр агуулсан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах | Сургууль, цэцэрлэгийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг шинэчлэн БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлуулах | Батлагдсан журам, жагсаалт, | Амны хөндийн эрүүл мэндийн эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, маркетингийн дэд ажлын хэсэг | ЭМЯ, НЭМГ БСШУСЯ | АШУҮИС-ийн НЭМС, АУС | 2019-2020 |
| | Сургууль, цэцэрлэгийн орчинд хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах | Төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтын тайлан | | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | Нийслэл, дүүргийн боловсролын газар | 2019-2022 |
| | Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн дунд чихэрлэг хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах МСС –ний материалыг боловсруулах, ажлуудыг зохион байгуулах | МСС –ын боловсруулсан материалын тоо, сурталчилгааны тоо, үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн тоо, үйл ажиллагааны тайлан | | НЭМҮТ АШУҮИС-ийн НЭМС, АУС | Нийслэл, дүүргийн боловсролын газар | 2019-2022 |
| 2.1.5 Чихэрлэг ундаанд агуулагдах чихрийн хэмжээг бууруулах | Хийжүүлсэн ундааны стандартад чихрийн агууламжийг тусгах, жимсний жүүсний чихрийн хэмжээг бууруулах нэмэлт өөрчлөлт оруулах | Өөрчлөлтийг тусгасан батлагдсан стандарт | Амны хөндийн эрүүл мэндийн эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, маркетингийн | ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ АШУҮИС-ийн НЭМС, АУС | АШУҮИС-ийн НЭМС, АУС | 2019-2022 он |
| | Чихэрлэг ундааны чихэрлэгийн агууламжид дотоодын болон хөндлөнгийн | Төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтын | | МХЕГ Шүдний мэргэжилтний | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хяналтыг тогтмол тавих | тайлан, дотоодын хяналтын тайлан | дэд ажлын хэсэг | холбоо | | |
| 2.1.6 Хүүхдийн шүдийг бэхжүүлэх уламжлалт аргыг сурталчлах; | Хүүхдийн шүдийг бэхжүүлэх уламжлалт аргуудын талаар эцэг эх, багш нарт зориулсан сургалт, сурталчилгааны материал (санамж, гарын авлага, шторк) боловсруулах | Боловсруулсан сургалт, сурталчилгааны материалын төрөл, тоо | Амны хөндийн эрүүл мэндийн эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, маркетингийн дэд ажлын хэсэг | ЭМЯ, НЭМГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ Аймаг нийслэлийн ЭМГ | ТББ-ууд | 2019-2022 |
| | Ам зайлах уусмалыг нэвтрүүлэх (Уламжлалт арга ) | Нэвтрүүлсэн технологи | | ЭТГ, УАУХ | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2020-2022 |
| ***Зорилт 3.* Шүдний өвчлөлийн оношилгоо, эмчилгээнд зайлшгүй шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эм материалын хангамжийг нэмэгдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах;** | | | | | | |
| ***3.1 Амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм материалыг нэмэгдүүлэх чиглэлээр:*** | | | | | | |
| 3.1.1 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн шүдний кабинетын хүчин чадлыг нэмэгдүүлэх; | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн шүдний кабинетэд байх зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүний нөөцийн үнэлгээ хийх | Үнэлгээний тайлан | Хөтөлбөрийн санхүүжилт, үр дүн, гүйцэтгэлийг хянах дэд ажлын хэсэг | ЭМЯ, ТЗУГ, ЭМХТ Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | ЭМЯ, ЭҮТГ, Аймаг, нийслэлийн ЭМГ ТББ-ууд | 2019-2022 |
| | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн шүдний кабинетэд байх зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн үнийн судалгаа хийх | Үнийн судалгааны тайлан | | ЭМЯ, ЭҮТГ Хөтөлбөрийн санхүүжилт, үр дүн, гүйцэтгэлийг хянах дэд ажлын хэсэг | ТББ-ууд | 2019-2022 |
| | Үнэлгээнд үндэслэн аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн шүдний кабинетэд шаардлагатай тоног төхөөрөмж, эм, | Тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан | Хөтөлбөрийн санхүүжилт, үр дүн, гүйцэтгэлийг хянах дэд | ЭМЯ, ЭЗСХОГ ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ | ЭМЯ, ОУБ-ууд | 2019-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эмнэлгийн хэрэгслээр хангах | аймаг, дүүргийн шүдний кабинетийн тоо | ажлын хэсэг | | | |
| 3.1.2 Сургуулийн шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх кабинетад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, ажиллах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, батлуулж, мөрдүүлэх; | Сургуулийн шүдний кабинетад тавигдах шаардлага, үйл ажиллагааны үзүүлэлт, ажиллах мэргэжилтний ажлын байрын тодорхойлолтыг боловсруулах, батлуулах | Тушаал шийдвэр Сургуулийн шүдний кабинетийн шалгуур үзүүлэлт Мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ, НЭМГ, ТЗУГ Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | Аймаг, нийслэлийн ЭМГ ЕБС-ууд | 2019-2020 |
| 3.1.3 Шүдний өвчний оношилгоо, эмчилгээний заавфыг шинэчлэн боловсруулж, батлуулж, мөрдүүлэх; | Шүдний өвчний оношилгоо, эмчилгээний заавфыг шинэчлэн боловсруулах | Батлагдсан заавар | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ, ЭТГ Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | ЭМЯ, ЭҮТГ Аймаг, нийслэлийн ЭМГ ЕБС-ууд | 2019-2020 |
| 3.1.4 Зорилтот бүлгийн хүүхдүүдийн дунд шүдний урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах | 24 сараас 12 насны хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо Үзлэгийн тайлан | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ, ЭТГ, Монголын Шүдний Мэргэжилтний Холбоо АШУҮИС, НАСС | Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ ХХЭМБ-ууд ЕБС-ууд | 2019-2020 |
| | Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах | Эмчлэн эрүүлжүүлсэн хүүхдийн тоо | | Монголын Шүдний Мэргэжилтний Холбоо, АШУҮИС, НАСС | Аймаг, нийслэлийн ЭМГ ЕБС-ууд ХХЭМБ-ууд | 2019-2020 |
| | Суралцагчдын эрүүл мэндийн дэвтрийг боловсруулж, ЕБС-ийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх | Суралцагчдын эрүүл мэндийн дэвтэр | Амны хөндийн эрүүл мэндийн эрүүл зан үйл төлөвшүүлэх | ЭМЯ, БТГ, НЭМГ БСШУСЯ | Аймаг, нийслэлийн ЭМГ ЕБС-ууд | 2019-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулсан дүүрэг, өрхийн эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, нэгдсэн эмнэлэг, иргэн, аж ахуйн нэгжийг шалгаруулах | Шалгарсан байгууллагын тоо | сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, маркетингийн дэд ажлын хэсэг | ЭМЯ-ны НЭМГ | Аймаг, нийслэлийн ЭМГ | 2020-2022 |
| | Нийгмийн хариуцлагын хүрээнд идэвхи санаачилгатай ажиллаж байгаа хувийн хэвшлийн шүдний эмнэлгийг шалгаруулах | Шалгарсан эмнэлгийн тоо | | ЭМЯ-ны НЭМГ | Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, ЭМНДЕГ | 2020-2023 |
| | Хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай бүлгийн хүүхдэд хүрч үйлчлэх | Хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай бүлгийн хүүхдэд хүүхдэд хүрч үйлчилсэн тоо | Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, эмчилгээ зохион байгуулах дэд ажлын хэсэг | ЭМЯ-ны ЭТГ | Аймаг, Нийслэлийн ЭМГ | 201-2023 |
| ***Зорилт 4.*** **Шүд-амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх;** | | | | | | |
| ***4.1 Шүдний өвчлөлийн бүртгэл мэдээлэл, тандалтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр:*** | | | | | | |
| 4.1.1 Шүдний өвчлөлийн болон урьдчилан сэргийлэлтийн мэдээллийн анхан шатны бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох; | Шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх болон шүдний өвчлөлийг бүртгэх мэдээллийн журам боловсруулах | Тушаал шийдвэр | Хөтөлбөрийн санхүүжилт, үр дүн, гүйцэтгэлийг хянах дэд ажлын хэсэг | ЭМЯ, ЭТГ ЭМХТ Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | ЭМЯ, ЭМЦМХ, Аймаг, нийслэлийн ЭМГ ЕБС-ууд | 2019-2020 |
| | Шүдний өвчлөлийн бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сантай болох; | Тушаал шийдвэр | | ЭМЯ, БТГ, ЭТГ Шүдний мэргэжилтний холбоо, | ЭМЯ, ЭМЦМХ, Аймаг, нийслэлийн | 2019-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэжлийн нийгэмлэг | ЭМГ | |
| | Цахим мэдээллийн нэгдсэн сангийн журам боловсруулах | Батлагдсан журам | | ЭМЯ, ЭМЦМХ, ЭМХТ<br>Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | ЭМХТ<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019 |
| 4.1.2 Шүд, нүүр амны эрүүл мэндийн чиглэлээр шинэ технологи, судалгааны ажлыг дэмжих; | Шүд, нүүр амны эрүүл мэндийн чиглэлээр судалгаа хийх | Судалгааны тайлан | Хөтөлбөрийн санхүүжилт, үр дүн, гүйцэтгэлийг хянах дэд ажлын хэсэг | ЭМЯ, ЭҮТГ, ЭТГ<br>АШУҮИС-ийн НАСС<br>Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | ЭМЯ, НЭМГ<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2022 |
| | Шүд, нүүр амны эрүүл мэндийн чиглэлд шинэ технологи нэвтрүүлж, оношилгоо эмчилгээний чадавхийг сайжруулах | Нэвтрүүлсэн шинэ технологи Тайлан | | ЭМЯ, ЭҮТГ, ШУТЗ<br>АШУҮИС-ийн НАСС<br>Шүдний мэргэжилтний холбоо, мэргэжлийн нийгэмлэг | Эрдэм шинжилгээний байгууллагууд<br>Аймаг, нийслэлийн ЭМГ | 2019-2022 |

ooOOoo